



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 10 өдөр

Дугаар А/385

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын Хүндэт жуух, өргөмжлөлийн хавтас захиалан хийлгэхэд 360000 төгрөг, Ховдын наадмын торгон дэвжээ ном худалдан авах зардалд 350000 төгрөг, шинээр сонгогдсон УИХ-ын гишүүдэд амжилт хүсэж, цаашдын хамтын ажллагааны чиглэлээр хийсэн уулзалтын зардалд 840 000 төгрөг, аймгийн Засаг дарга Булган, Алтай, Үенч сумдад ажиллахад нутгийн ахмадууд өгсөн гарын бэлэгний зардалд 400650 төгрөг, Хөрөнгө оруулалтын хяналтаар ажилласан Зам, тээврийн яамны албаны хүмүүст олгосон гарын бэлэгний зардалд 184 000 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 2 134 650 төгрөг /Хоёр сая нэг зуун гучин дөрвөн мянга зургаан зуун тавин /-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ